

**ХҮНИЙ ХУВИЙН МЭДЭЭЛЭЛ ХАМГААЛАХ ТУХАЙ
ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН
ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

**УЛААНБААТАР ХОТ
2020 он**

ХУВЬ ХҮНИЙ МЭДЭЭЛЭЛ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН ҮНЭЛГЭЭ НЭГ.ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Энэхүү үнэлгээний ажлын гол зорилго нь Хувь хүний мэдээлэл хамгаалах тухай хуулийн төслийн зарим зохицуулалт /зүйл, хэсэг, заалт/-д тодорхой шалгуур үзүүлэлтийн дагуу дүн шинжилгээ хийх, үр нөлөөг тооцож, давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, хуулийн зохицуулалтыг ойлгомжтой, хэрэгжихэд хууль хоорондын зөрчилдөөн үүсэхгүй байдлаар боловсруулах, хуулийн төслийн чанарыг сайжруулахад оршино.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 17-д “төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй. Хүний эрх, нэр төр, алдар хүнд, улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хангах зорилгоор задруулж үл болох төр, байгууллага, **хувь хүний нууцыг хуулиар тогтоон хамгаална.**” гэж заасан бөгөөд 1995 онд Хувь хүний нууцын тухай хуулийг баталсан.

Хувь хүний нууцын тухай хуулийн 5 дугаар зүйлд хувь хүн нууцаа өөрөө хамгаалахаар заасан. Харин шаардлагатай тохиолдолд хувь хүний нууцыг хууль тогтоомжид заасан үндэслэл, журмын дагуу төр, байгууллага хамгаалалтдаа авч болох бөгөөд энэ тохиолдолд хуулиар тусгайлан эрх олгогдсон төрийн байгууллагын эрх бүхий албан тушаалтан зөвхөн хууль тогтоомжид заасан үндэслэл, журмын дагуу хувь хүний нууцтай танилцах эрхтэй. Хувь хүний нууцыг мэдсэн этгээд задруулахыг хориглох талаар заасан хэдий ч Монгол Улсын батлан хамгаалах болон үндэсний аюулгүй байдлын ашиг сонирхол, иргэдийн эрүүл мэнд, хууль ёсны эрх ашигт хохирол учрахаар бол ил болгохыг зөвшөөрсөн байна¹.

Хэдийгээр хүчин төгөлдөр үйлчилж байгаа Хувь хүний нууцын тухай хууль байгаа хэдий ч хувь хүний мэдээллийг хэрхэн хамгаалах нарийвчилсан зохицуулалт бүхий хууль одоогоор байхгүй байна.

Иймд Хувь хүний мэдээлэл хамгаалах тухай хуулийн төсөл /цаашид “хуулийн төсөл” гэх/-ийн зарим зохицуулалтын үр нөлөөг үнэлэхдээ Хууль тогтоомжийн тухай хууль, “Хуулийн төслийн үр нөлөө үнэлэх аргачлал”² /цаашид “аргачлал” гэх/-д заасны дагуу дараах үе шаттайгаар хийлээ:

- 1.1.Шалгуур үзүүлэлтийг сонгох;
- 1.2.Хуулийн төслөөс үр нөлөө үнэлэх хэсгээ тогтоох;
- 1.3.Урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг тооцох;
- 1.4. Үр дүнг үнэлэх, зөвлөмж өгөх.

¹ Хувь хүний нууцын тухай хуулийн 5, 6 дугаар зүйл.

² Хууль тогтоомжийн тухай хуулийн 12.1-д заасны дагуу Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан.

ХОЁР.ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ

Энэхүү үнэлгээг хийхдээ хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудал нь Монгол Улсын Үндсэн хуульд “хувь хүний нууцыг хуулиар хамгаалах” талаар заасан баталгаатай уялдаатай байна. Иймд хувь хүний нууцыг хуулиар хамгаалахаар Монгол Улсын Үндсэн хуульд заасан болон Хувь хүний нууцын тухай хууль хүчин төгөлдөр байгааг харгалзан хуулийн төслийн зүйл, заалт өөр хоорондоо болон хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжтой уялдсан эсэх, хувь хүний мэдээлэл хамгаалах чиг үүргийг төрийн байгууллага зайлшгүй хэрэгжүүлэх шаардлагатай эсэх, уг чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх боломжтой эсэхийг шалгах нь ач холбогдолтой байгааг харгалзан Аргачлалд заасан шалгуур үзүүлэлтээс “Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийг сонголоо.

Дээрх шалгуур үзүүлэлтийг тухайлан сонгох болсон үндэслэл нь хуулийн төслийн зүйл, заалтад тодорхой шалгуур үзүүлэлтийн дагуу дүн шинжилгээ хийх, үр нөлөөг тооцож, давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, улмаар хуулийн төслийн чанарыг сайжруулахад энэхүү судалгааны ажлын гол зорилго оршино.

Тодруулбал, хуулийн төслийн үзэл баримтлалд “... Монгол Улсын Их Хурал 1995 онд Хувь хүний нууцын тухай хуулийг баталж, уг хуулиар хувь хүний нууцыг тогтоох, хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулж, хувь хүн нууцаа өөрөө хамгаалах, хувь хүний нууцыг хуулийн дагуу болон итгэмжлэлээр олж мэдсэн этгээд бусдад задруулахыг хориглох, шаардлагатай тохиолдолд хувь хүний нууцыг хууль тогтоомжид заасан үндэслэл, журмын дагуу төр, байгууллага хамгаалалтдаа авч болохоор тусгасан.

Түүнчлэн хувь хүний нууцын төрлийг тогтоож, хувь хүний нууцыг ил болгох үндэслэл, энэ хуулиар хамгаалсан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл шүүхэд гомдол гаргах эрх болон хууль зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлагын талаар зохицуулсан нь Монгол Улсын Үндсэн хуулиар тогтоосон хүний эрх, эрх чөлөөг баталгаажуулахад томоохон хувь нэмэр оруулсан хэдий ч нийгмийн харилцаа тасралтгүй хөгжиж байгаа энэ цаг үед нийгэмд үүсээд байгаа зарим төрлийн асуудлыг зөвхөн Хувь хүний нууцын тухай хуулиар зохицуулахад бэрхшээлтэй нөхцөл байдлууд үүссээр байгааг дурдах нь зүйтэй.

Сүүлийн жилүүдэд үйлчилгээний газруудад хэрэглэгчийн худалдан авалтын үнийн дүнд суурилсан оноо цуглуулах, хувь хүнийг таньж баталгаажуулах зорилгоор иргэний биеийн давхцахгүй өгөгдөл /гарын хурууны хээ/ болон хувь хүний бусад мэдээлэл цуглуулах нь түгээмэл байгаа бөгөөд ингэхдээ хувь хүний мэдээллийг тухайн хувь хүнд урьдчилан мэдэгдэж зөвшөөрөл авалгүйгээр цуглуулах, анх цуглуулсан зорилгоос өөр зорилгоор ашиглах, бусдад дамжуулах, хувь хүний мэдээлэл алдагдах эрсдэл үүссэн тохиолдолд эргэн мэдэгдэх, мэдээллийн аюулгүй байдлыг хамгаалах зэрэг асуудал үүсэхэд Хувь хүний нууцын тухай хуулийг хэрэглэхэд зохицуулалтын агуулга нь хэт ерөнхий, тунхаглалын шинжтэй, тодорхой төрлийн асуудлыг шийдвэрлэж чадахгүйд хүргэж байна.

Түүнчлэн дүрс бичлэгийн төхөөрөмж ашиглан хувь хүний мэдээлэл цуглуулах, хувь хүний эрх, хууль ёсны ашиг сонирхолд сөргөөр нөлөөлөх мэдээллийг олон нийтэд түүний зөвшөөрөлгүйгээр ил болгох, бусдад дамжуулах үйлдлүүд ихээхэн нэмэгдэж байгаа бөгөөд энэ нь дүрс бичлэгийн төхөөрөмжийг байршуулж болох

тохиолдлуудыг хуулиар нарийвчлан заагаагүй, түүнд тавигдах шаардлагыг тодорхойлоогүй, хориглох зохицуулалт байхгүй, хяналт тавьдаггүй зэрэгтэй холбоотой гэж үзэж байна.

Мөн Иргэний хууль, Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хууль, Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай зэрэг хуулиудаар хувь хүний мэдээллийг хадгалах, хамгаалах, нууцлах, зөвшөөрөл авах, нийтлэх, тараах, хариуцлага хүлээлгэх зэрэг зарим харилцааг зохицуулж, хувийн мэдээллийг ашигласны улмаас хувь хүнд хохирол үүссэний дараа эрүүгийн хэрэг үүсгэгдэн, цөөн тооны хэрэг шүүхээр шийдвэрлэгдэж байна.

Хэдийгээр дээр дурдсан хуулиудаар зарим төрлийн харилцааг зохицуулж байгаа боловч хувь хүний мэдээллийг цуглуулах, бүртгэх, хадгалах, дамжуулах, ашиглах, өөрчлөх, устгах зэрэг мэдээлэл боловсруулалтын үйл ажиллагаа явуулахад мэдээллийн эзэн болон хувь хүний мэдээллийг цуглуулж, боловсруулж, ашиглаж байгаа этгээд хоорондын эрх зүйн харилцааг тусгайлан зохицуулсан хууль байхгүй, эрх олгосон, зөвшөөрсөн, хориглосон үйлдлийг нарийвчлан зохицуулаагүй байдал нь иргэдэд ойлгомжгүй байдал үүсгэж, Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын гэрээ, бусад хуульд заасан хүний эрх, эрх чөлөө зөрчигдөхөд хүргэж болзошгүй байна.

Хуулийн төслийн үзэл баримтлалд хуулийн төсөл дараах бүтэцтэй байхаар тусгасан байна.

Хуулийн төслийн нэгдүгээр бүлэг буюу нийтлэг үндэслэлд хуулийн төслийн зорилт, хуулийн үйлчлэх хүрээг тодорхойлж, хуульд хэрэглэсэн нэр томъёоны тодорхойлолт, хувь хүний мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглахад баримтлах зарчмыг тусгана. Хуулийн төсөлд хувь хүний мэдээлэл, эмзэг мэдээлэлд юуг хамааруулах, хувь хүний мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглах, хувь хүний мэдээлэл хариуцагч /controller/, хувь хүний мэдээлэл боловсруулагч /processor/, генетикийн болон биометрик мэдээлэл зэрэг нэр томъёог бусад улс орны жишигт тулгуурлан тодорхойлно.

Хуулийн төслийн хоёрдугаар бүлэгт хувь хүний мэдээлэл цуглуулахад мэдээллийн эзнээс зөвшөөрөл авах, төрийн байгууллага, иргэн, хуулийн этгээд хувь хүний мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглаж болох үндэслэлийг тогтооно. Мөн хувь хүний эмзэг мэдээлэл, биометрик мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглах нөхцөл болон түүхийн болон шинжлэх ухааны судалгаа, шинжилгээний зорилгоор мэдээлэл боловсруулах, ашиглах зохицуулалтыг тусгана. Түүнчлэн мэдээллийн эзэн нас барсан тохиолдолд тухайн хувь хүний мэдээллийг хэрхэх талаар хуулийн төсөлд холбогдох журмыг оруулна.

Хуулийн төслийн гуравдугаар бүлэгт хувь хүний мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглахад мэдээллийн эзний эдэлж болох эрх, хүлээх үүргийг тогтооно.

Хуулийн төслийн дөрөвдүгээр бүлэгт мэдээлэл хариуцагчийн мэдээллийн эзний өмнө хүлээх үүрэг, мэдээлэл хариуцагч гэрээний үндсэн дээр мэдээлэл цуглуулах, боловсруулах үүргийг мэдээлэл боловсруулагчид шилжүүлсэн тохиолдолд мэдээлэл боловсруулагчийн хүлээх үүргийг тусгана;

Хуулийн төслийн тавдугаар бүлэгт хувь хүний мэдээлэл хамгаалах талаар аюулгүй байдлын арга хэмжээ авах, мэдээллийн эзэнд мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглахтай холбоотой мэдэгдэл өгөх тохиолдол, зөрчлийг мэдэгдэх, нөлөөллийн үнэлгээ хийх талаар оруулна.

Хуулийн төслийн зурагдугаар бүлэгт хувь хүний мэдээлэл хамгаалах эрх бүхий байгууллагыг тогтоож, энэ хуулийн хэрэгжилтийг хянаж ажиллах чиг үүргийг тодорхой болгоно.

Хуулийн төслийн долдугаар бүлэгт дүрс бичлэгийн төхөөрөмжийг байршуулах тохиолдол, дүрс бичлэгийн системд тавигдах шаардлага, хориглох, хяналт тавих зохицуулалтыг тусгана.

Хуулийн төслийн наймдугаар бүлэгт хувь хүний мэдээллийг боловсруулах, хамгаалах талаар хориглох зүйл, хууль зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагатай холбоотой бусад зүйлийг тусгана.

Хуулийн төслийн үзэл баримтлалд хуулийн төсөл батлагдсанаар нийгэм, эдийн засаг, хууль зүйн дараах үр дагавар гарна гэж тодорхойлсон байна. Үүнд:

1.Хувь хүний мэдээлэл хамгаалах эрх зүйн орчин бүрдэж, хувь хүн буюу мэдээллийн эзнээс түүний мэдээллийг цуглуулах, боловсруулах талаар зөвшөөрөл авах тогтолцоо бүрдэнэ;

2.Хувь хүн буюу мэдээллийн эзэн, хувь хүний мэдээлэл хариуцагч болон боловсруулагчийн эрх, үүргийг тогтоосноор хувь хүний мэдээллийг анх цуглуулсан зорилгоос өөр зорилгоор ашиглахад хязгаар тогтоох, хувь хүний мэдээлэл алдагдахаас урьдчилан сэргийлж, хүний эрхийн баталгаа дээшилнэ;

3.Хувь хүний мэдээллийг боловсруулах, хамгаалах талаар хориглох зүйлийг тогтоож, аливаа гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэн үр дүнтэй тогтолцоог бүрдүүлнэ.” гэх эдгээр зорилгод нийцүүлэн тусгасан зохицуулалт нь харилцан уялдаа бүхий бусад хуультай уялдсан эсэхэд дүн шинжилгээ хийх нь зүйтэй гэж үзэн дээрх шалгуур үзүүлэлтийг сонголоо.

“Харилцан уялдаа” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг бүхэлд нь сонгож, хуулийн төслийн зүйл, хэсэг, заалт өөр хоорондоо болон Монгол Улсын Үндсэн хууль, бусад холбогдох хуульд нийцсэн эсэх, бусад байгууллагын чиг үүрэгтэй давхардсан, зөрчилдсөн эсэх, уг чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх боломжтой эсэхийг үнэлэхдээ аргачлалд заасан асуултад хариулах замаар болон холбогдох бусад хуулийн зохицуулалттай харьцуулах замаар шалгахар сонгов.

ГУРАВ.ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ХЭСГИЙГ ТОГТООСОН-БАЙДАЛ

Аргачлалд заасны дагуу хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтийг сонгосон тул түүнд хамаарах үр нөлөөг үнэлэх хэсгээ тогтоохдоо хуулийн төслийн үзэл баримтлалд дурдсан хамгийн чухал, ач холбогдолтой зүйл, хэсэг, заалтыг сонголоо:

Д/д	Шалгуур үзүүлэлт	Үр нөлөөг үнэлэх хэсэг
3.1	Харилцан уялдаа	Аргачлалд заасан асуултад хариулахад хуулийн төслийг бүхэлд нь сонгов.
3.2	Харилцан уялдаа	Хууль хоорондын зөрчилдөөн үүсэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор Монгол Улсын Үндсэн хууль болон одоогоор хувь хүний мэдээллийг хамгаалахад ач холбогдол бүхий бусад холбогдох хуулийн зохицуулалттай уялдсан эсэх, хамаарал бүхий байгууллагын хуулиар хүлээсэн чиг үүрэгтэй давхардсан, зөрчилдсөн эсэхийг тогтоохоор холбогдох хуультай харьцуулан судлахад хуулийн төслийг бүхэлд нь сонгов.

ДӨРӨВ.ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ

Аргачлалд заасны дагуу хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлт, үр нөлөөг үнэлэх хэсгийг тус тус тогтоож, тэдгээрт тохирох шалгах хэрэгслийг дараах байдлаар тодорхойллоо:

Д/д	Шалгуур үзүүлэлт	Үр нөлөөг үнэлэх хэсэг	Тохирох шалгах хэрэгсэл
4.1	Хуулийн төслийн Харилцан уялдаа	Аргачлалд заасан асуултад хариулахад хуулийн төслийг бүхэлд нь сонгов.	Хуулийн төслийн уялдаа холбоог шалгах: Аргачлалын 4.10-т заасан асуултаар хуулийн төслийн уялдаа холбоог шалгахдаа хуулийн төслийг бүхэлд нь сонгон, асуултад хариулах замаар шалгана.
4.2	Хууль хоорондын Харилцан уялдаа	Хууль хоорондын зөрчилдөөн үүсэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор Монгол Улсын Үндсэн хууль болон одоогоор хувь хүний мэдээллийг хамгаалахад ач холбогдол бүхий бусад холбогдох хуулийн зохицуулалттай уялдсан эсэх, хамаарал бүхий байгууллагын хуулиар хүлээсэн чиг үүрэгтэй давхардсан, зөрчилдсөн эсэхийг тогтоохоор холбогдох хуультай харьцуулан судлахад хуулийн төслийг бүхэлд нь сонгов.	Хууль хоорондын уялдаа холбоог шалгах: Хуулийн төсөл болон бусад хууль тогтоомжын уялдаа холбоог шалгахдаа хувь хүний мэдээлэлд хамаарах зохицуулалт бүхий хуулийн төслийг зохицуулалтыг тогтоож харьцуулах замаар шалгана.

4.1.Шалгуур үзүүлэлт: Хуулийн төслийн харилцан уялдаа

Энэхүү шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зохицуулалт өөр хоорондоо болон бусад хуультай уялдах уялдаа холбоог сайжруулах, хууль тогтоомжийн давхардал, хийдэл, зөрчлийг тогтоох зорилгоор Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал”-ын 4.10-т заасан шалгуурт нийцүүлэн боловсруулсан асуултад хариулах байдлаар хуулийн төслийг бүхэлд нь шалгаж үзэв.

Хүснэгт 3

Д/д	Асуултууд	Хариулт
1	Хуулийн төслийн зохицуулалт тухайн хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх;	Тийм
2	Хуулийн төслийн “Хууль тогтоомж” гэсэн хэсэгт заасан хуулиудын нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн эсэх;	Тийм
3	Хуулийн төсөлд тодорхойлсон нэр томьёо тухайн хуулийн төслийн болон бусад хууль тогтоомжийн нэр томьёотой нийцэж байгаа эсэх;	Хуулийн төсөл нь анхдагч хуулийн төсөл хэлбэрээр боловсруулагдсан байх бөгөөд шинэ нэр томьёог тусгасан. Хуулийн төслийн зохицуулалт өөр хоорондоо уялдаатай байна. Харин бусад хуультай хэрхэн уялдсан эсэхийг дараагийн шатанд шалгана.
4	Хуулийн төслийн хэсэг, заалт тухайн хуулийн төслийн заалттай нийцэж байгаа эсэх;	Тийм
5	Хуулийн төслийн хэсэг, заалт тухайн хуулийн төслийн заалттай давхардсан эсэх;	Үгүй.
6	Хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан эсэх;	Тийм.
7	Хуулийн төсөлд шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх;	Үгүй.
8	Хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх;	Үгүй
9	Төрийн байгууллагын чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх боломжтой эсэх;	Боломжтой бөгөөд энэ талаар хуульд тусгасан.
10	Татварын хуулиас бусад хуулийн төсөлд албан татвар, төлбөр, хураамж тогтоосон эсэх;	Үгүй
11	Тухайн хуулийн төсөлд тусгасан тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалтыг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд тусгасан эсэх;	Үгүй

12	Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгасан эсэх;	Үгүй
13	Хуулийн төслийн хэсэг, заалт жендэрийн эрх тэгш байдлыг хангасан эсэх;	Тийм
14	Хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх;	Үгүй.
15	Хуулийн төсөлд авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх;	Үгүй
16	Хуулийн төсөлд тусгасан хориглосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх.	Тийм. Холбогдох хуульд заасны дагуу хууль зөрчигчид хариуцлага хүлээлгэхээр заасан байх боловч Зөрчлийн тухай хуульд зөрчлийг тусгах талаар дагах хуулийн төсөл боловсруулаагүй байна.

Энэхүү шалгуур үзүүлэлтийн хүрээнд аргачлалын 4.10-т заасан шалгуурт нийцүүлэн боловсруулсан асуултад хариулах байдлаар хуулийн төслийн зохицуулалт өөр хоорондоо зөрчил, давхардал үүсгэсэн эсэхийг шалгасан бөгөөд хуулийн төслийн зохицуулалт давхардал, зөрчилгүй байна. Хууль зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлага, зөрчлийг шалгах эрх бүхий этгээдийн асуудал тодорхойгүй байх тул Зөрчлийн тухай болон Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулж, хуулийн төслийг уялдуулах шаардлагатай байна.

4.2.Шалгуур үзүүлэлт: Хууль хоорондын харилцан уялдаа

Энэхүү шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зохицуулалт бусад хуультай уялдах уялдаа холбоог сайжруулах, хууль тогтоомжийн давхардал, хийдэл, зөрчлийг тогтоох зорилгоор Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал”-ын 4.10-т заасан шалгуурт нийцүүлэн хуулийн төслөөс шалгах аар сонгосон зохицуулалтыг бусад хуулийн зохицуулалттай харьцуулах байдлаар шалгав.

Хүснэгт 4

Д/д	Холбогдох хуулийн зохицуулалт	Хуулийн төслийн зохицуулалт	Харьцуулалт
1	Монгол Улсын Үндсэн хууль		
	Арван зургадугаар зүйл Монгол Улсын иргэн дараахь үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлнэ:	1 дүгээр зүйл. Хуулийн зорилт 1.1.Энэ хуулийн зорилт нь хувь хүний эрх, эрх чөлөөнд хууль бусаар халдахаас урьдчилан	Монгол Улсын Үндсэн хуульд заасны дагуу хүний хувийн болон гэр бүл, захидал харилцааны нууц,

	13/халдашгүй, чөлөөтэй байх эрхтэй. ... Иргэний хувийн ба гэр бүл, захидал харилцааны нууц, орон байрны халдашгүй байдлыг хуулиар хамгаална; 17/төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй. Хүний эрх, нэр төр, алдар хүнд, улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хангах зорилгоор задруулж үл болох төр, байгууллага, хувь хүний нууцыг хуулиар тогтоон хамгаална;	сэргийлж, хувь хүний мэдээллийг цуглуулах, боловсруулах, ашиглах, түүний аюулгүй байдлыг хангахтай холбоотой эрх зүйн харилцааг зохицуулахад оршино. 2 дугаар зүйл.Хувь хүний мэдээлэл хамгаалах хууль ТОГТООМЖ 2.1.Хувь хүний мэдээлэл хамгаалах тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Хувь хүний нууцын тухай хууль, Нийтийн мэдээллийн тухай хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.	орон байрны халдашгүй байдал, мөн хүний эрх, нэр төр, алдар хүнд зэрэг мэдээллийг хуулиар хамгаалахаар заасанд нийцүүлэн хувь хүний мэдээллийг хамгаалахаар хуулийн төсөл боловсруулсан байна. Тухайлбал, хуулийн төсөл хүний эрх, эрх чөлөөнд хууль бусаар халдахаас урьдчилан сэргийлж, хувь хүний мэдээллийг цуглуулах, боловсруулах, ашиглах, түүний аюулгүй байдлыг хангахад чиглэсэн байна.
2	Иргэний хууль		
	1 дүгээр зүйл. Иргэний нэр, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг хамгаалах 21.4.Хуулиар тогтоосон хувийн нууцад хамааралтай мэдээг өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр тарааснаас гэм хор учирсан гэж үзвэл иргэн уг гэм хорыг арилгахыг шаардах эрхтэй. 21.5.Иргэний дүрсийг гэрэл зураг, кино, дүрс бичлэгийн хальс, хөрөг зураг болон бусад хэлбэрээр өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр нийтэлсэн, олон нийтэд үзүүлснээс гэм хор учирсан гэж үзвэл тухайн этгээд гэм	4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно: 4.1.1.“хувь хүний мэдээлэл” гэж хувь хүний эмзэг мэдээлэл болон хувь хүний ургийн овог, эцэг, эхийн нэр, өөрийн нэр, төрсөн он, сар, өдөр, төрсөн газар, оршин суугаа газрын хаяг, байршил, хувь хүнийг илэрхийлэх дугаар, боловсрол, санхүү, гэр бүлийн байдал, албан тушаал, цахим тодрхойлогч, хувь хүнийг шууд болон шууд бусаар тодорхойлох боломжтой бусад	Иргэний хуульд “хуулиар тогтоосон хувийн нууцад хамааралтай мэдээ”, “нас барсан хүний хувийн нууцтай холбоотой мэдээ” гэх зэргээр заасан байна. Харин хуулийн төсөлд туссан “хувь хүний мэдээлэл” нь Хувь хүний нууцын тухай хуульд зааснаас өргөн хүрээнд байна. Өөрөөр хэлбэл, төсөлд заасан “хувь хүний мэдээлэл” нь хуульд заасан нууцад хамаарах

	хорыг арилгахыг шаардах эрхтэй. 21.7.Нас барсан этгээдийн нэр, нэр төр, алдар хүндийг гутаасан, эсхүл түүний хувийн нууцтай холбоотой мэдээг энэ хуулийн 520 дугаар зүйлд заасан өвлөгчийн зөвшөөрөлгүйгээр олон нийтэд тараасан бол энэ зүйлд заасан журам нэгэн адил үйлчилнэ. 520 дугаар зүйл.Хууль ёсны өвлөгч 520.1.Дор дурдсан этгээдийг хууль ёсны өвлөгч гэх бөгөөд тэдгээр нь адил хэмжээгээр өвлөх эрхтэй. 520.1.1.нас барагчийн нөхөр, эхнэр, төрүүлсэн болон үрчилж авсан, түүнийг нас барсан хойно төрсөн хүүхэд, нас барагчийн төрүүлсэн болон үрчилсэн эцэг, эх; 520.1.2.энэ хуулийн 520.1.1-д заасан өвлөгч байхгүй, эсхүл тэдгээр нь өвлөхөөс татгалзсан буюу өвлөх эрхээ алдсан бол нас барагчийн өвөг эцэг, эмэг эх, ах, эгч, дүү, ач, зээ.	мэдээллийг; 6 дугаар зүйл. Мэдээлэл цуглуулахад зөвшөөрөл авах 6.1.Хуульд зааснаас бусад тохиолдолд мэдээлэл хариуцагч мэдээллийн эзнээс зөвшөөрөл авсны үндсэн дээр мэдээлэл цуглуулна. 14 дүгээр зүйл. Мэдээллийн эзний эрх 14.1... 12 дугаар зүйл. Мэдээллийн эзэн нас барсны дараа мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглах 12.1.Мэдээллийн эзэн нас барсан, эсхүл нас барсанд тооцогдсон бол түүний гэр бүлийн гишүү, хууль ёсны төлөөлөгч, харгалзан дэмжигчийн бичгээр өгсөн зөвшөөрлөөр түүнд хамаарах мэдээллийг цуглуулж, боловсруулж, ашиглана. 12.2.Мэдээллийн эзэн нас барснаас хойш 70 жил өнгөрсөн тохиолдолд хувь хүний эмзэг мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглахад зөвшөөрөл шаардахгүй.	мэдээлэл мөн эсэх талаар хуулийн төсөлд тодорхой заагаагүй байна. Иймд хоорондоо харилцан уялдаа бүхий хуулийн нэр томъёог уялдуулах, “хувь хүний мэдээлэл”-д хамаарах мэдээллийг нууцад хамаарах эсэхийг тодорхой заах шаардлагатай. Түүнчлэн Иргэний хуульд “нас барсан этгээдийн хувийн нууцтай холбоотой мэдээллийг хууль ёсны өвлөгчийн зөвшөөрлөөр авахаар заасан байх бөгөөд хуулийн төсөлд энэхүү хүрээг хязгаарласан байна. Мөн хуулийн төсөлд нас барснаас хойш 70 жил өнгөрсөн тохиолдолд хувь хүний мэдээллийг цуглуулах, боловсруулах, ашиглахад зөвшөөрөл шаардахгүй байхаар заасан нь Иргэний хуульд заасан хууль ёсны өвлөгчийн зөвшөөрлийг шаардахгүй байхаар заасан зөрчилтэй байна.
3	Хувь хүний нууцын тухай хууль		
	1 дүгээр зүйл.	1 дүгээр зүйл.	Хувь хүний нууцын

	Хуулийн зорилт Энэ хуулийн зорилт нь хувь хүний нууцыг тогтоох, хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино. 2 дугаар зүйл.Хувь хүний нууцын тухай ойлголт "Хувь хүний нууц" гэж Монгол Улсын болон гадаадын иргэн, харъяалалгүй хүн Монгол Улсын хууль тогтоомжид нийцүүлэн нууцалсан бөгөөд задруулбал тухайн хүний хууль ёсны ашиг сонирхол, нэр төр, алдар хүндэд илтэд хохирол учруулж болзошгүй мэдээ, баримт бичиг, биет зүйлийг хэлнэ. 4 дүгээр зүйл.Хувь хүний нууцын төрөл 1.Хувь хүний нууц нь дараахь төрөлтэй байна: 1/захидал харилцааны нууц; 2/эрүүл мэндийн нууц; 3/хөрөнгийн нууц; 4/гэр бүлийн нууц; 5/хуулиар тогтоосон бусад нууц. 2.Захидал харилцаа, эрүүл мэнд, хөрөнгө, гэр бүлийн нууц гэдгийг энэ хуульд дараахь утгаар ойлгоно: 1/захидал харилцааны нууцад захидал, цахилгаан, илгээмж, өргөдөл зэрэг шуудан холбооны хэрэгслээр бусад хүн, байгууллагатай солилцож буй мэдээ, баримт бичиг, биет зүйлийг; 2/эрүүл мэндийн нууцад тухайн хувь хүний бие эрхтний гажиг, нийтэд аюултай онцлог зарим халдварт өвчнөөс бусад	Хуулийн зорилт 1.1.Энэ хуулийн зорилт нь хувь хүний эрх, эрх чөлөөнд хууль бусаар халдахаас урьдчилан сэргийлж, хувь хүний мэдээллийг цуглуулах, боловсруулах, ашиглах, түүний аюулгүй байдлыг хангахтай холбоотой эрх зүйн харилцааг зохицуулахад оршино. 2 дугаар зүйл.Хувь хүний мэдээлэл хамгаалах хууль тогтоомж 2.1.Хувь хүний мэдээлэл хамгаалах тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Хувь хүний нууцын тухай хууль, Нийтийн мэдээллийн тухай хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ .3 дугаар зүйл.Хууль үйлчлэх хүрээ 3.1.Энэ хуулиар хүн, хуулийн этгээд, төрийн байгууллага нь хувь хүний мэдээлэл /цаашид "мэдээлэл" гэх/ цуглуулах, боловсруулах, ашиглах, хамгаалахтай холбоотой харилцааг зохицуулна. 4 дүгээр зүйл. Хуулийн нэр томьёоны тодорхойлолт	тухай хууль хувь хүний нууцыг тогтоох, хамгаалах зорилготой бол, Хуулийн төсөл хувь хүний эрх, эрх чөлөөнд хууль бусаар халдахаас урьдчилан сэргийлж, хувь хүний мэдээллийг цуглуулах, боловсруулах, ашиглах, түүний аюулгүй байдлыг хангах зорилготой. Үүнээс үзэхэд Хувь хүний нууцын тухай хууль болон Хувь хүний мэдээлэл хамгаалах тухай хуулийн төсөл зорилгын хувьд давхардаагүй харилцааг зохицуулж байгаа боловч хоорондоо салшгүй холбоотой байна. Мөн хуулийн төсөлд заасан "хувь хүний мэдээлэл", "хувь хүний эмзэг мэдээлэл" бүхэлдээ хувь хүний нууцад хамаарах эсэх нь тодорхойгүй байна. Өөрөөр хэлбэл, Хувь хүний нууцын тухай хуульд заасан "хуулиар тогтоосон бусад нууц"-д хамаарах эсэхийг тодорхой тусгах шаардлагатай. Мөн эрүүл мэндийн нууц, эрүүл мэндийн
--	--	--	--

өвчнөөр өвчилсөн тухай мэдээллийг; 3/хөрөнгийн нууцад зөвхөн эд хөрөнгө, оюуны өмч, эрхийн эзэн, эсхүл түүний итгэмжлэгдсэн хүмүүс мэдэх, түүнчлэн эрх бүхий байгууллага албан тушаалтны албан үүргийнхээ дагуу олж мэдсэн мэдээ, баримт бичиг, тоо, гэрээ хэлцэл, биет зүйлийг; 4/гэр бүлийн нууцад бусдад задруулбал тухайн хувь хүн, түүний гэр бүлийн гишүүдийн нэр төр, алдар хүнд, ашиг сонирхолд харшлах мэдээллийг. 3.Хувь хүний өөрийн архив, хадгаламж, тэмдэглэл, битүүмжлэл болон тэдгээрт хамаарах дүрс, дуу бичлэгийг нууцалж болно. 5 дугаар зүйл.Хувь хүний нууцыг хамгаалах 1.Хувь хүн нууцаа өөрөө хамгаална. 2.Шаардлагатай тохиолдолд хувь хүний нууцыг хууль тогтоомжид заасан үндэслэл, журмын дагуу төр, байгууллага хамгаалалтдаа авч болно. 3.Хуулиар тусгайлан эрх олгогдсон төрийн байгууллагын эрх бүхий албан тушаалтан зөвхөн хууль тогтоомжид заасан үндэслэл, журмын дагуу хувь хүний нууцтай танилцана. 4.Хувь хүний нууцыг хуулийн дагуу болон итгэмжлэлээр олж мэдсэн этгээд бусдад задруулахыг хориглоно. 6 дугаар зүйл.Хувь хүний нууцыг ил болгох Монгол Улсын батлан хамгаалах болон үндэсний аюулгүй байдлын ашиг	4.1.1.“хувь хүний мэдээлэл” гэж хувь хүний эмзэг мэдээлэл болон хувь хүний ургийн овог, эцэг, эхийн нэр, өөрийн нэр, төрсөн он, сар, өдөр, төрсөн газар, оршин суугаа газрын хаяг, байршил, хувь хүнийг илэрхийлэх дугаар, боловсрол, санхүү, гэр бүлийн байдал, албан тушаал, цахим тодрхойлогч, хувь хүнийг шууд болон шууд бусаар тодорхойлох боломжтой бусад мэдээллийг; 4.1.2. “хувь хүний эмзэг мэдээлэл” гэж хувь хүний үндэс, угсаа, арьсны өнгө, улс төр, шашин шүтлэг, итгэл үнэмшил, үйлдвэрчний эвлэлийн гишүүнчлэл, генетик, биометрик, эрүүл мэнд, ял эдэлж байгаа болон ял эдэлсэн эсэх, бэлгийн чиг хандлага, бэлгийн амьдралын талаарх мэдээллийг; 4.1.12.“эрүүл мэндийн мэдээлэл” гэж хувь бүний бие махбодийн болон сэтгэцийн эрүүл мэнд, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авсан тухай мэдээллийг. Тавдугаар бүлэг Мэдээлэл хамгаалах үйл ажиллагаа 18 дугаар зүйл. Аюулгүй байдлыг хангах арга хэмжээ	мэдээллийн харилцан уялдааг тодорхой заагаагүй нь цаашид маргаан үүсэх, гэмт хэрэг, зөрчлийг шалгахад ойлгомжгүй байдал үүсгэхээр байна. Учир нь Эрүүгийн хууль, Иргэний хуульд хувь хүний нууцад хамаарах мэдээллийг хамгаалсан зохицуулалт туссан байна. Үүнээс үүдэн хувь хүний нууцыг ил болгох, шүүхэд гомдол гаргах асуудалд “хувь хүний мэдээлэл”, “хувь хүний нууц”-д хамаарах мэдээллийг давхцал ойлгомжгүй байдал үүсгэхээр байна. Хувь хүний нууцын тухай хуульд хувь хүн нууцаа өөрөө хамгаалах үүрэг хүлээсэн байдаг бол, хуулийн төсөлд мэдээлэл хариуцагч, боловсруулагч, ашиглагчтай холбоотойгоор хувь хүний мэдээлэл хамгаалах эрх бүхий байгууллага нь ХЭҮК байхаар тодорхой заасан байна.
--	---	--

	сонирхол, иргэдийн эрүүл мэнд, хууль ёсны эрх ашигт хохирол учруулахгүйн үүднээс зайлшгүй шаардлагатай онцгой тохиолдолд төрийн холбогдох эрх бүхий байгууллага /албан тушаалтан/ -ын шийдвэрээр хувь хүний эрүүл мэндийн болон бусад нууцыг хуульд заасан хүрээнд ил болгож болно. 7 дугаар зүйл.Шүүхэд гомдол гаргах Энэ хуулийн 5 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан этгээд өөрийнх нь нууцыг бусдад задруулсан гэж үзвэл хувь хүн энэ тухай гомдлоо шүүхэд гаргах эрхтэй.	22 дугаар зүйл.Хувь хүний мэдээлэл хамгаалах эрх бүхий байгууллага 22.1.Хувь хүний мэдээлэл хамгаалах эрх бүхий байгууллага нь Хүний эрхийн үндэсний комисс /цаашид “хамгаалах байгууллага” гэх/ байна.	
4	Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хууль		
	3 дугаар зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт 3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно: 3.1.1.“Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс” гэж Монгол Улсын Үндсэн хууль, хууль, олон улсын гэрээнд заасан хүний эрх, эрх чөлөөний хэрэгжилтэд хяналт тавьж, хүний эрхийг хамгаалах, дэмжих чиг үүрэг бүхий хараат бус, бие даасан үндэсний байгууллагыг;	22 дугаар зүйл.Хувь хүний мэдээлэл хамгаалах эрх бүхий байгууллага 22.1.Хувь хүний мэдээлэл хамгаалах эрх бүхий байгууллага нь Хүний эрхийн үндэсний комисс /цаашид “хамгаалах байгууллага” гэх/ байна.	Хуулийн төсөлд хувь хүний мэдээлэл хамгаалах эрх бүхий байгууллага нь ХЭҮК байхаар тодорхой заасан нь сайшаалтай боловч хуулийн төсөлд товчлолыг хэрэглэхдээ “хамгаалах байгууллага” гэж товчлохоор заасан нь Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд заасантай уялдаагүй байна. Тодруулбал, уг хуульд “комисс” гэж товчлол хэрэглэсэн байгаатай уялдуулах нь нэг байгууллагын хувьд ойлгомжтой,

			төөрөгдөл үүсгэхгүй байхаар байна.
5	Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль		
	11 дүгээр зүйл.Мэдээлэл авах 11.1.Иргэн, хуулийн этгээд нь хүний эрх, эрх чөлөө, үндэсний аюулгүй байдал, байгууллагын хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор хууль тогтоомжид нийтэд мэдээлэхийг хориглосноос бусад дараах мэдээллийг энэ хуулийн 3.1-д заасан байгууллагаас авах эрхтэй: 11.1.1.тухайн байгууллагын эзэмшилд байгаа бүх төрлийн мэдээ, баримт бичиг, гэрээ, контракттай холбоотой мэдээлэл; 11.1.2.тухайн байгууллагын эзэмшилд байгаа эд зүйлтэй холбоотой мэдээлэл; 11.1.3.тухайн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой бусад мэдээлэл. 11.2.Мэдээлэл авах тухай иргэн, хуулийн этгээдийн хүсэлтийг хүлээн авч байгаа энэ хуулийн 3.1-д заасан байгууллагын холбогдох албан тушаалтан иргэнд энэ хуульд зааснаас бусад шаардлага тавихыг хориглоно. 11.3.Мэдээлэл авах тухай иргэн, хуулийн этгээдийн хүсэлт дараах шаардлагыг хангасан байна: 11.3.1.хүсэлт гаргагч нь иргэн бол эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, оршин суугаа газрын буюу цахим шуудангийн хаяг, утасны дугаар, иргэний үнэмлэх,	Хоёрдугаар бүлэг Мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглах 6-13 дугаар зүйл Гуравдугаар бүлэг Мэдээллийн эзний эрх 14-15 дугаар зүйл 19 дүгээр зүйл. Мэдээллийн эзэнд мэдэгдэл өгөх 19.1.Дараах тохиолдолд мэдээллийн эзэнд мэдэгдэл өгнө: 19.1.1.хувь хүний эмзэг мэдээллийг ашигласан; 19.1.2.мэдээллийн эзний зөвшөөрлөөр мэдээлэл боловсруулахаас бусад үндэслэл, зорилгоор мэдээлэл боловсруулахад мэдээллийг гуравдагч этгээдэд дамжуулсан.	Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуульд мэдээлэл авах эрх, мэдээлэл хүсэгчийн эрх, үүргийг заасан бөгөөд хувь хүний нууцыг хамгаалах зохицуулалтыг тусгасан байна. Харин хуулийн төсөл батлагдсан тохиолдолд хувь хүний нууц, хувь хүний мэдээллийн давхцал нь мөн дээр дурдсан хуулийн зохицуулалтыг хэрэгжүүлэхэд зөрчилдөөн үүсгэхээр байна.

эсхүл түүнтэй адилтгах бичиг баримтын дугаарыг бичиж, гарын үсгээ зурсан байх; 11.3.2.хүсэлт гаргагч нь хуулийн этгээд бол нэр, хаяг буюу цахим шуудангийн хаяг, улсын бүртгэлийн дугаараа бичиж, хуулийн этгээдийг төлөөлөх эрх бүхий этгээд гарын үсгээ зурсан байх. 11.4.Иргэн энэ хуулийн 11.3.1-д заасны дагуу хүндэтгэн үзэх шалтгаанаар гарын үсгээ зурж чадахгүй бол бусдаар төлөөлүүлэн зуруулж болох бөгөөд хүсэлтийг иргэд бичгээр хамтран гаргасан бол түүнд бүгд гарын үсэг зурах, эсхүл тэдгээрийн төлөөлөгч гарын үсэг зурж, төлөөлөх эрхээ нотлох баримт бичгийг хавсаргана. 12 дугаар зүйл.Мэдээлэл хүсэгчийн эрх, үүрэг 12.2.Мэдээлэл хүсэгч мэдээлэл авахдаа дараах үүрэг хүлээнэ: 12.2.1.хууль заасан мэдээлэл авах журмыг биелүүлэх; 12.2.2.мэдээлэл авах эрхээ хэрэгжүүлэхдээ Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль, бусдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчихгүй байх; 12.2.3.авах мэдээллээ бодитой тодорхойлсон байх. 20 дугаар зүйл.Хувь хүний нууцыг хамгаалах 20.1.Хуульд өөрөөр заагаагүй бол хувь хүн бичгээр зөвшөөрснөөс бусад тохиолдолд түүний эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, нас, хүйс, мэргэжил, боловсрол,		
---	--	--

	албан тушаал, ажлын газрын хаяг, ажлын утаснаас бусад мэдээллийг бусдад задруулахыг хориглоно.		
6	Улсын бүртгэлийн ерөнхий хууль		
	3.1.5.“улсын бүртгэлийн мэдээллийн нэгдсэн сан” гэж нэгдсэн ангилал, код, индекс, арга зүй, стандарт, баримт бичгийн шаардлага болон хуульд заасны дагуу цуглуулж, боловсруулж, хадгалсан иргэн, хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн цаасан болон цахим мэдээллийн бүрдлийг; 6 дугаар зүйл.Иргэний улсын бүртгэлийн төрөл 6.1.Иргэний улсын бүртгэл дараах төрөлтэй байна: 6.1.1.төрсний; 6.1.2.гэрлэсний; 6.1.3.гэрлэлт дуусгавар болсны; 6.1.4.гэрлэлт сэргээсний; 6.1.5.эцэг /эх/ тогтоосны; 6.1.6.үрчилсний; 6.1.7.овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр өөрчилсний; 6.1.8.нас барсны; 6.1.9.иргэний үнэмлэхийн; 6.1.10.үндэсний гадаад паспорт, түүнийг орлох бичиг баримтын; 6.1.11.биеийн давхцахгүй өгөгдлийн /гарын хурууны хээ/; 6.1.12.оршин суугаа газрын хаягийн; 6.1.13.шилжилт хөдөлгөөний; 6.1.14.Монгол Улсын харьяат болсон, харьяатаас гарсан, иргэний харьяаллыг сэргээн тогтоосны; 6.1.15.хүйс өөрчлөгдсөний.	4 дүгээр зүйл. Хуулийн нэр томьёоны тодорхойлолт 4.1.1.“хувь хүний мэдээлэл” гэж хувь хүний эмзэг мэдээлэл болон хувь хүний ургийн овог, эцэг, эхийн нэр, өөрийн нэр, төрсөн он, сар, өдөр, төрсөн газар, оршин суугаа газрын хаяг, байршил, хувь хүнийг илэрхийлэх дугаар, боловсрол, санхүү, гэр бүлийн байдал, албан тушаал, цахим тодрхойлогч, хувь хүнийг шууд болон шууд бусаар тодорхойлох боломжтой бусад мэдээллийг; 4.1.2. “хувь хүний эмзэг мэдээлэл” гэж хувь хүний үндэс, угсаа, арьсны өнгө, улс төр, шашин шүтлэг, итгэл үнэмшил, үйлдвэрчний эвлэлийн гишүүнчлэл, генетик, биометрик, эрүүл мэнд, ял эдэлж байгаа болон ял эдэлсэн эсэх, бэлгийн чиг хандлага, бэлгийн амьдралын талаарх мэдээллийг 4.1.12. “эрүүл мэндийн мэдээлэл” гэж хувь бүний бие махбодийн болон сэтгэцийн эрүүл мэнд, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авсан тухай	Хуулийн төсөлд заасан нэр томьёо нь Улсын бүртгэлийн ерөнхий хуульд заасан иргэний улсын бүртгэлийн төрлийн нэр томьёотой уялдаагүй байгаа нь хуулийн төсөлд тусаагүй бусад мэдээлэл нь энэхүү хуулийн төслийн хамгаалалтад хамаарахгүй мэт ойлголтыг үүсгэж байна. Энэ нь мэдээлэл хариуцагч, боловсруулагч, ашиглагч мэдээллийн аюулгүй байдлыг хангахдаа энэ талаар анхаарахгүй орхих боломжтой мэт ойлголт төрүүлэхээр байна.

	12.3.Улсын бүртгэлийн мэдээллийн нэгдсэн сангийн дараах мэдээлэл хаалттай байна: 12.3.1.иргэний биеийн давхцахгүй өгөгдлийн /гарын хурууны хээ/ бүртгэл; 12.3.2.төрийн нууцад хамааруулсан үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэл; 12.3.3.Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан арга хэмжээг авахад хөтөлсөн улсын бүртгэлийн мэдээлэл.	мэдээллийг	
7	Зөрчлийн тухай хууль		
		25 дугаар зүйл.Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага 25.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ. 25.2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.	Холбогдох зүйлийг тусгасан хэдий ч дагаж гарах хуулийн төсөл боловсруулах шаардлагатай. Тухайлбал, хуулийн төслийн зохицуулалтыг зөрчсөн үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй тохиолдолд хэрхэн хариуцлага хүлээлгэх нь тодорхойгүй байна.
8	Эрүүгийн хууль		
	1.3 дугаар зүйл.Шударга ёсны зарчим 2.Гэмт хэрэгт тооцох, ял оногдуулахад хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, бэлгийн болон хүйсийн чиг баримжаа, боловсрол, хөгжлийн бэрхшээлтэй байдлаар ялгаварлан гадуурхахгүй. 13.8 дугаар зүйл.	4 дүгээр зүйл. Хуулийн нэр томьёоны тодорхойлолт 4.1.2.“хувь хүний эмзэг мэдээлэл” гэж хувь хүний үндэс, угсаа, арьсны өнгө, улс төр, шашин шүтлэг, итгэл үнэмшил, үйлдвэрчний эвлэлийн гишүүнчлэл, генетик, биометрик, эрүүл мэнд, ял эдэлж байгаа болон ял эдэлсэн эсэх, бэлгийн	Хуулийн төслийн 4.1.2 дахь заалт нь Эрүүгийн хуульд “бэлгийн болон хүйсийн чиг баримжаа” гэх нэр томьёо хэрэглэсэнтэй зөрчилдөж байна. Эрүүгийн хуульд “дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэг” гэх нэр томьёог ашигласан бол хуулийн төсөл “дүрс бичлэгийн

Зөвшөөрөлгүй гэрэл зураг авах, дуу, дүрс бичлэг хийж дамжуулах, тараах 1.Оршин суугчийн зөвшөөрөлгүйгээр орон байранд, эсхүл гадна талаас орон байрны доторх орчны гэрэл зураг авч, эсхүл дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэг хийж олон нийтэд тараасан, эсхүл бусдад дамжуулсан бол дөрвөн зуун тавин нэгжээс хоёр мянга долоон зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас зургаан сар хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ. 3.Эрх бүхий албан тушаалтан хуульд заасан үндэслэл, журмыг зөрчиж орон байранд, гадна талаас орон байрны доторх орчны гэрэл зураг авсан, дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэг хийсэн бол дөрвөн зуун тавин нэгжээс хоёр мянга долоон зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас зургаан сар хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ. 4.Эрх бүхий албан тушаалтан хуульд заасан үндэслэл, журмыг зөрчиж авсан гэрэл зураг, дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийг олон нийтэд тараасан нь мөрдөн шалгах ажиллагааны нууцыг задруулах гэмт хэргийн	чиг хандлага, бэлгийн амьдралын талаарх мэдээллийг. 25 дугаар зүйл.Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага 25.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ. 25.2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ. Долдугаар бүлэг Дүрс бичлэгийн систем 23 дугаар зүйл.Дүрс бичлэгийн систем	систем, төхөөрөмж” гэх зэрэг нэр томъёог хэрэглэснийг уялдуулах нь зүйтэй байна.
--	--	---

	шинжгүй бол хоёр жил хүртэл хугацаагаар эрх хасаж зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. Тайлбар: -Энэ бүлэгт заасан “эрх бүхий албан тушаалтан” гэж хуульд заасны дагуу мөрдөн шалгах, хэрэг бүртгэх, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа, гүйцэтгэх ажил явуулах эрх бүхий хүнийг ойлгоно.		
	13.10 дугаар зүйл.Хувь хүний нууцад халдах 1.Хувь хүний хуулиар хамгаалагдсан нууцыг хууль бусаар олж авсан, бусдад дамжуулсан бол дөрвөн зуун тавин нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ. 2.Энэ гэмт хэргийг: 2.1.харилцаа холбоо, цахим хэрэгсэл ашиглаж; 2.2.эрх бүхий албан тушаалтан хуульд заасан үндэслэл, журмыг зөрчиж үйлдсэн бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. 13.11 дүгээр зүйл.Хувь хүний нууцыг задруулах	25.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ. 25.2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.	Хуулийн төсөлд хувь хүний мэдээлэл хамгаалах хуулийг зөрчсөн тохиолдолд Эрүүгийн хуульд заасан хариуцлага хүлээлгэхээр заасан боловч Эрүүгийн хуульд хувь хүний нууцыг хамгаалах зорилгоор гэмт хэргийг тусгасан нь хувь хүний мэдээлэл хамгаалахтай холбогдох эсэх нь тодорхойгүй байдлыг үүсгэсэн байна.

	1.Хувь хүний хуулиар хамгаалагдсан нууцыг олж мэдсэн хүн өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр задруулсан бол дөрвөн зуун тавин нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ. 2.Албан үүргээ гүйцэтгэх явцад олж мэдсэн хувь хүний нууцыг задруулсан бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.		
	14.2 дугаар зүйл.Мэдээлэл хайх, хүлээн авахад саад учруулах 1.Төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах иргэний эрхийг хэрэгжүүлэхэд хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж саад учруулсан бол дөрвөн зуун тавин нэгжээс хоёр мянга долоон зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас зургаан сар хүртэл	25.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ. 25.2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.	Хуулийн төсөлд Эрүүгийн хуульд заасан хариуцлага хүлээлгэхээр заасан ч хувь хүний мэдээлэл нь хувь хүний нууцад хамаарах эсэхийг хуулийн төсөлд тодорхой заагаагүй байгаа нь ял завшуулах нөхцөлийг бүрдүүлэхээр байна.

	хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.		
--	---	--	--

Энэхүү шалгуур үзүүлэлтийн хүрээнд аргачлалын 4.10-т заасан шалгуурт нийцүүлэн боловсруулсан асуултад хариулах байдлаар хуулийн төслийн зохицуулалт өөр хоорондоо зөрчил, давхардал үүсгэсэн эсэхийг өмнөх хэсэгт шалгасан. Харин энэ хэсэгт хууль хоорондын зөрчилдөөн үүсэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор хуулийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль болон одоогоор хувь хүний мэдээллийг хамгаалахад ач холбогдол бүхий бусад хуулийн зохицуулалттай уялдсан эсэх, хамаарал бүхий байгууллагын хуулиар хүлээсэн чиг үүрэгтэй давхардсан, зөрчилдсөн эсэхийг тогтоохоор холбогдох хуультай харьцуулан шалгав. Хуулийн төсөл Монгол Улсын Үндсэн хуулийн зохицуулалттай уялдсан байх бөгөөд дараах хуулийн зохицуулалттай уялдах шаардлагатай байна:

Иргэний хууль

Иргэний хуульд “хуулиар тогтоосон хувийн нууцад хамааралтай мэдээ”, “нас барсан хүний хувийн нууцтай холбоотой мэдээ” гэх зэргээр заасан байх тул хуулийн төсөлд туссан “хувь хүний мэдээлэл” нь Хувь хүний нууцын тухай хуульд ямар хүрээнд хамаарахыг ойлгомжтой тусгах шаардлагатай байна. Түүнчлэн Иргэний хуульд “нас барсан этгээдийн хувийн нууцтай холбоотой мэдээллийг хууль ёсны өвлөгчийн зөвшөөрлөөр” авахаар заасан байх бөгөөд хуулийн төсөлд хүнийг нас барснаас хойш 70 жил өнгөрсөн тохиолдолд хувь хүний мэдээллийг цуглуулах, боловсруулах, ашиглахад зөвшөөрөл шаардахгүй байхаар заасан байна. Иймд хуулийн төслийн уг зохицуулалтыг Иргэний хуульд заасан хууль ёсны өвлөгчийн эрхтэй уялдуулах нь зүйтэй байна.

Хувь хүний нууцын тухай хууль

Хувь хүний нууцын тухай хууль нь хувь хүний нууцыг тогтоох, хамгаалах зорилготой, харин хуулийн төсөл хувь хүний эрх, эрх чөлөөнд хууль бусаар халдахаас урьдчилан сэргийлж, хувь хүний мэдээллийг цуглуулах, боловсруулах, ашиглах, түүний аюулгүй байдлыг хангах зорилготой байгаа нь зохицуулалтын зорилгын хувьд давхардаагүй байна. Гэвч хууль төсөл болон тус хууль нь хоорондоо салшгүй холбоотой байна.

Хуулийн төсөлд заасан “хувь хүний мэдээлэл”, “хувь хүний эмзэг мэдээлэл” бүхэлдээ хувь хүний нууцад хамаарах эсэх нь тодорхойгүй байна. Өөрөөр хэлбэл, Хувь хүний нууцын тухай хуульд заасан “хуулиар тогтоосон бусад нууц”-д хамаарах эсэхийг, эрүүл мэндийн нууц, эрүүл мэндийн мэдээллийн харилцан уялдаа зэргийг тодорхой заагаагүй нь цаашид маргаан үүсэх, гэмт хэрэг, зөрчлийг шалгахад ойлгомжгүй байдал үүсгэхээр байна.

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хууль

Харин Хувь хүний нууцын тухай хуульд хувь хүн нууцаа өөрөө хамгаалах үүрэг хүлээхээр заасан бол Хувь хүний мэдээллийг хамгаалах тухай хуулийн төсөлд хувь хүний мэдээлэл хамгаалах эрх бүхий байгууллага нь Хүний эрхийн Үндэсний Комисс байхаар тодорхой заасан байна.

Харин хуулийн төсөлд хувь хүний мэдээлэл хамгаалах эрх бүхий байгууллага нь Хүний эрхийн Үндэсний Комисс байхаар зааж, тухайн байгууллагын нэрийг товчлон хэрэглэхдээ “хамгаалах байгууллага” гэж товчлохоор заасан нь Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд “комисс” гэж товчлол хэрэглэсэн байгаатай уялдаагүй байна. Хэдийгээр энэ нь хууль хоорондын

зөрчилдөөн, давхардал үүсгэхгүй боловч хууль тус бүрийн зохицуулалт нэг байгууллагын хувьд ойлгомжтой, төөрөгдөл үүсгэхгүй байх нь оновчтой байна.

Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль

Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуульд мэдээлэл авах эрх, мэдээлэл хүсэгчийн эрх, үүргийг заасан бөгөөд хувь хүний нууцыг хамгаалах зохицуулалтыг тусгасан байна. Харин хуулийн төсөл батлагдсан тохиолдолд хувь хүний нууц, хувь хүний мэдээллийн давхцал нь мөн дээр дурдсан хуулийн зохицуулалтыг хэрэгжүүлэхэд зөрчилдөөн үүсгэхээр байна.

Улсын бүртгэлийн ерөнхий хууль

Хуулийн төсөлд заасан хувь хүний мэдээлэлд хамаарах нэр томьёо нь Улсын бүртгэлийн ерөнхий хуульд заасан иргэний улсын бүртгэлийн төрлийн нэр томьёотой уялдаагүй байгаа нь хуулийн төсөлд тусаагүй бусад нэршилд хамаарах мэдээлэл нь энэхүү хуулийн төслийн хамгаалалтад хамаарахгүй мэт ойлголтыг үүсгэж байна. Энэ нь мэдээлэл хариуцагч, боловсруулагч, ашиглагч мэдээллийн аюулгүй байдлыг хангахдаа энэ талаар анхаарахгүй орхих боломжтой нөхцөл байдал үүсгэх эрсдэлтэй байна.

Зөрчлийн тухай хууль

Хууль зөрчсөн этгээдэд Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэхээр заасан хэдий ч Зөрчлийн тухай хуульд Хувь хүний мэдээлэл хамгаалах тухай хууль зөрчихтэй холбоотой зөрчил байхгүй байна. Иймд Зөрчлийн тухай хуульд зөрчлийг тусгах зорилгоор дагаж гарах хуулийн төсөл боловсруулах шаардлагатай байна.

Эрүүгийн хууль

Хуулийн төсөлд хувь хүний мэдээлэл, хувь хүний эмзэг мэдээлэлд хамаарах мэдээллийг заасан нь Эрүүгийн хуульд заасан “бэлгийн болон хүйсийн чиг баримжаа” гэх нэр томьёотой зөрчилдөж байна. Түүнчлэн хуулийн төслийн “дүрс бичлэгийн систем, төхөөрөмж” гэх нэр томьёо нь Эрүүгийн хуульд заасан “дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэг” гэх нэр томьёотой уялдаагүй байна.

Хуулийн төсөлд хувь хүний мэдээлэл хамгаалах хуулийг зөрчсөн тохиолдолд Эрүүгийн хуульд заасан хариуцлага хүлээлгэхээр заасан боловч Эрүүгийн хуульд хувь хүний нууцыг хамгаалах зорилгоор гэмт хэргийг тусгасан нь хувь хүний мэдээлэл хамгаалахтай холбогдох эсэх ойлгомжгүй нөхцөлийг үүсгэж байна.

ТАВ. ҮР ДҮНГ ҮНЭЛЖ, ЗӨВЛӨМЖ ӨГӨХ

Үр дүнг үнэлж, зөвлөмж өгөх үе шатыг аргачлалын 5-д заасны дагуу дараах дарааллаар хийлээ:

- 5.1.үр дүнг баримтжуулах;
- 5.2.үнэлэх;
- 5.3.зөвлөмж өгөх.

5.1.Үр дүнг баримтжуулах: Хувь хүний мэдээлэл хамгаалах тухай хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх ажиллагааг холбогдох шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн бөгөөд холбогдох хууль тогтоомж, бусад эрх зүйн акт болон хамаарал бүхий холбогдох мэдээлэл зэрэг бусад материалыг ашиглаж, ашигласан материалын жагсаалтыг үнэлгээний тайланд хавсаргаснаас гадна үнэлгээ хийсэн хуулийн төслийг хавсаргасан болно.

Хуулийн төслийн зохицуулалт өөр хоорондоо болон бусад хуультай хэрхэн уялдсан гэсэн шалгуур үзүүлэлтийн дагуу хийсэн үнэлэлтийг нэгтгэн дараах дүгнэлтийг хийж, зөвлөмж боловсрууллаа.

5.2.Дүгнэлт: Харилцан уялдааг хангасан байдал

Хуулийн төслийг харилцан уялдаа гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд бүхэлд нь аргачлалд заасан асуултад хариулах болон бусад хуультай харьцуулах байдлаар шалгахад хуулийн төслийн зохицуулалт өөр хоорондоо болон Монгол Улсын Үндсэн хуультай зөрчилдөөгүй, ямар нэг давхардалгүй байна. Харин Иргэний хууль, Хувь хүний нууцын тухай хууль, Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Эрүүгийн хуультай уялдуулах, Зөрчлийн тухай болон Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулж, хуулийн төслийг уялдуулах шаардлагатай байна. /Энэ талаар энэхүү үнэлгээний 4.2 дахь хэсэгт тодорхой тусгасан болно./

5.3.Зөвлөмж:

Хувь хүний мэдээлэл хамгаалах тухай хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх ажлын явцад гарсан дараах асуудлыг анхаарч, хуулийн төслийг боловсронгуй болгох, чанарыг сайжруулах чиглэлээр өөрчлөлт оруулах нь зүйтэй гэсэн зөвлөмжийг хууль санаачлагчид өгч байна:

- ✓ Иргэний хуульд “хуулиар тогтоосон хувийн нууцад хамааралтай мэдээ”, “нас барсан хүний хувийн нууцтай холбоотой мэдээ” гэх зэргээр заасан байх тул хуулийн төсөлд туссан “хувь хүний мэдээлэл” нь Хувь хүний нууцын тухай хуульд заасан нууцад хэрхэн хамаарахыг ойлгомжтой тусгах;
- ✓ Иргэний хуульд “нас барсан этгээдийн хувийн нууцтай холбоотой мэдээллийг хууль ёсны өвлөгчийн зөвшөөрлөөр” авахаар заасан зохицуулалтад хуулийн төслийн “хүнийг нас барснаас хойш 70 жил өнгөрсөн тохиолдолд хувь хүний мэдээллийг цуглуулах, боловсруулах, ашиглахад зөвшөөрөл шаардахгүй байх” зохицуулалтыг уялдуулах;
- ✓ хуулийн төсөлд заасан “хувь хүний мэдээлэл”, “хувь хүний эмзэг мэдээлэл” бүхэлдээ хувь хүний нууцад хамаарах эсэх, уялдаа холбоог тодорхой ойлгомжтой болгох;
- ✓ хуулийн төсөлд хувь хүний мэдээлэл хамгаалах эрх бүхий байгууллага нь Хүний эрхийн үндэсний комисс байхаар зааж, тухайн байгууллагын нэрийг товчлон хэрэглэхдээ “хамгаалах байгууллага” гэж товчлохоор заасныг Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд “комисс” гэж товчлол хэрэглэсэнтэй уялдуулах боломжтой эсэхийг судлах;

- ✓ Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуульд мэдээлэл авах эрх, мэдээлэл хүсэгчийн эрх, үүргийг заасан бөгөөд хувь хүний нууцыг хамгаалах зохицуулалтыг тусгасан байна. Харин хуулийн төсөл батлагдсан тохиолдолд хувь хүний нууц, хувь хүний мэдээллийн давхцал нь мөн дээр дурдсан хуулийн зохицуулалтыг хэрэгжүүлэхэд зөрчилдөөн үүсгэхээр байх тул эдгээр зохицуулалтыг тодорхой болгох;
- ✓ хуулийн төсөлд заасан хувь хүний мэдээлэлд хамаарах нэр томьёо нь Улсын бүртгэлийн ерөнхий хуульд заасан иргэний улсын бүртгэлийн төрлийн нэр томьёотой уялдаагүй байх тул хуулийн төсөл хамаараагүй нэршилд хамаарах мэдээлэл нь энэхүү хуулийн төслийн хамгаалалтад хамаарах эсэхийг тодорхой болгох;
- ✓ Зөрчлийн тухай хуульд Хувь хүний мэдээлэл хамгаалах тухай хууль зөрчих зөрчил тусгах талаар арга хэмжээ авах;
- ✓ Хуулийн төсөлд хувь хүний мэдээлэл, хувь хүний эмзэг мэдээлэлд хамаарах мэдээллийг заасан нь Эрүүгийн хуульд заасан “бэлгийн болон хүйсийн чиг баримжаа” гэх нэр томьёотой, мөн хуулийн төслийн “дүрс бичлэгийн систем, төхөөрөмж” гэх нэр томьёо нь Эрүүгийн хуульд заасан “дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэг” гэх нэр томьёотой тус тус зөрчилдөхөөр байх тул уялдуулах;
- ✓ хуулийн төсөлд хувь хүний мэдээлэл хамгаалах хуулийг зөрчсөн тохиолдолд Эрүүгийн хуульд заасан хариуцлага хүлээлгэхээр заасан боловч Эрүүгийн хуульд хувь хүний нууцыг хамгаалах зорилгоор гэмт хэргийг тусгасан нь хувь хүний мэдээлэл хамгаалахтай холбогдох эсэх ойлгомжгүй нөхцөлийг үүсгэж байгааг тодорхой болгох, ял завших нөхцөлийг бүрдүүлэхгүй байхад анхаарах.

Ашигласан мэдээлэл, судалгаа, гарын авлага, хууль тогтоомжийн жагсаалт

Хууль тогтоомжийн жагсаалт

- Монгол Улсын Үндсэн хууль
- Хууль тогтоомжийн тухай хууль
- Хувь хүний нууцын тухай хууль
- Иргэний хууль
- Улсын бүртгэлийн ерөнхий хууль
- Иргэний улсын бүртгэлийн тухай хууль
- Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль
- Зөрчлийн тухай хууль
- Эрүүгийн хууль
- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль

Монгол Улсын Их Хурлын тогтоол

- Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг, 2020
- Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл, 2017
- Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, 2020

Монгол Улсын Засгийн газрын тогтоол

- Монгол Улсын Засгийн газрын тогтоол, Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал 2016 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралт

Ашигласан мэдээлэл, судалгаа, гарын авлага

- Өгөгдөл хамгаалах тухай хуулийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалсан судалгааны тайлан, 2019

Интернэт эх сурвалж

- www.legalinfo.mn
- <https://cabinet.qld.gov.au/documents>

---oOo---